

**“УЛААНБААТАР ЛИФТ” НӨҮГ-ЫН СПОРТЫН  
ТАВАН ТӨРӨЛТ ТЭМЦЭЭНИЙ ТАЙЛАН МЭДЭЭ**


2023 оны 09 дүгээр сарын 21

Улаанбаатар хот

Монгол улсын биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийг үндэслэн, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, биеийн тамир, спортын хамтлагийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, ажилтан албан хаагчдын биеийн тамир, спортын үйл ажиллагаанд өргөнөөр хамруулах, тэдний идэвх сонирхлыг дэмжих зорилготой “Нийслэлийн Засаг Даргын нэрэмжит Нийслэлийн Нутгийн Захиргааны байгууллагуудын спортын v наадам”-ын хүрээнд байгууллагын аварга шалгаруулах 5 төрөлт тэмцээнийг зохион байгуулан ажиллаа. Үүнд:

1. Ажлын байрны дасгал хөдөлгөөн хийх;
2. Албан хаагчдын дунд Дартсны аварга шалгаруулах тэмцээн;
3. Албан хаагчдын дунд сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн;
4. Албан хаагчдын дунд волейболын аварга шалгаруулах тэмцээн;
5. 100м-ийн гүйлтийн тэмцээн (эрэгтэй, эмэгтэй) тус тус зохион байгууллаа.

1. “Ажлын байрны дасгал хөдөлгөөн”-ийг эрчимжүүлэх зорилгоор 2023 оны 09 дүгээр сарын 20-ний өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд ажлын байрны дасгал хөдөлгөөн зохион байгуулж ажилласан бөгөөд ажлын байрны дасгал хөдөлгөөнийг өглөө бүр хийж хэвшүүлж байна.





2. Албан хаагчдын дунд “Дартс”-ын аварга шалгаруулах тэмцээнийг ажлын байранд дээр зохион байгуулж, 3 багт хуваагдсан өрсөлдсөн бөгөөд 1-р байранд ахлах нягтлан бодогч Д.Санжням, механик инженер Я.Батбаатар, механик Б.Баяртогтох, Д.Бямбажав нар шалгарлаа.



3. Мөн 3Х3 “Сагсан бөмбөг”-ийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулж, 4 багт хуваагдан өрсөлдсөн бөгөөд 1-р байранд хяналтын инженер Б.Батзориг, ахлах нягтлан бодогч Д.Санжням, механик Д.Бямбажав нар шалгарав.





4.Эрэгтэй албан хаагчдын 100м-ийн гүйлтийн аварга шалгаруулах тэмцээнийг амжилттай зохион байгуулсан.

Нэгдүгээр байр: Г.Бадамрагчаа шалгарлаа.



5. Биеийн тамир, спортын хамтлагийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, байгууллагын нийт ажилчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2023 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр заал авч нөхөрсөг “Волейбол”-ын тэмцээн зохион байгуулж, байгууллагын аварга тоглогчоо шалгаруулав.

Байгууллагын аваргаар : Нэгдүгээр байр : Б.Батзориг

Хоёрдугаар байр: Г.Бадамрагчаа

Гуравдугаар байр: Н.Нарангуа нар тус тус шалгарлаа.







ХЯНАСАН:  
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

М.ЭНХБАТ

ТАЙЛАН БИЧСЭН:  
ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР

Б.БАЙГАЛЬ